

## 2-р шат



Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) нь Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн Сантай хамтран MICS Plus (ОУБТС+) судалгааг 2020 оны 9 сараас хэрэгжүүлж эхэлсэн. MICS Plus нь COVID-19 цар тахлын үед хүүхэд, гэр бүл, өрхийн нөхцөл байдлыг тодорхойлох өгөгдлийг бий болгож, шийдвэр гаргагчид болон оролцогч талуудад мэдээлнэ. Энэхүү хормын хувилбарт 2020 оны 12 сарын 1-ээс 14-ний хооронд дуудлага хийгдсэн 2-р шатны үр дүнг нэгтгэн харуулав.



## Судалгааны хэрэгжилт

### Хамрагалтын түвшин

1-р шат (2020 оны 9 сарын 18 - 10 сарын 25)	Орлуулалтын өмнө	Орлуулалтын дараа
<b>Түүвэрлэсэн өрх</b>	<b>2200</b>	<b>2200</b>
Ярилцлага авсан	1854	2126
Татгалзсан	90	17
Ярилцлага өгөх чадвартай өрхийн гишүүн байхгүй	0	2
Дуудлагад хариулагч нь сонгогдсон өрхөд амьдардаггүй	24	8
Утасны дугаар нь ашиглалтанд байхгүй	9	1
Ярилцлага дараа авахаар тохирсон боловч ярилцлага авагдаагүй	14	3
Дуудлагад хэн ч хариулаагүй/холбогдох боломжгүй	85	22
Сонгогдсон өрх холбоо барих утасгүй	27	6
Хаяг дээр өрхгүй	95	15
Бусад	2	0
<b>Шаардлага хангасан өрх</b>	<b>2103</b>	<b>2185</b>
<b>Хамрагалтын түвшин (хувь)</b>	<b>88.2</b>	<b>97.3</b>

### 2-р шат


(2020 оны 12 сарын 1-14)

<b>Түүвэрлэсэн өрх</b>	<b>2154</b>
Ярилцлага авсан	1987
Татгалзсан	40
Ярилцлага өгөх чадвартай өрхийн гишүүн байхгүй	1
Утасны дугаар нь ашиглалтанд байхгүй	3
Ярилцлага дараа авахаар тохирсон боломж ярилцлага авагдаагүй	16
Дуудлагад хэн ч хариулаагүй/холбогдох боломжгүй	107
<b>Шаардлага хангасан өрх</b>	<b>2154</b>
<b>Хамрагалтын түвшин (хувь)</b>	<b>92.2</b>

Судалгааны түүврийг ҮСХ-ны Хүн амын өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-аас авсан. 2020 оны 1-р сарын байдлаар бүртгэлд суурилсан Хүн ам, орон сууцны тооллыг түүврийн хүрээ болгон ашигласан. Нийт түүврийн зорилтот хэмжээ 2200 өрх. 1-р шатанд "Ойролцоо хөрш" загварт суурилсан аргаар оруулсны дараа хамрагалтын түвшин 97 хувь байсан. 2-р шат нь эхний шатанд татгалзсан, дуудлагад хариулагч нь сонгогдсон өрхөд амьдардаггүй, сонгогдсон өрх холбоо барих утасгүй, хаяг дээр өрхгүй тохиолдуудыг хасч 2,154 өрхийг судалгаанд хамруулахыг зорьсон. 2-р шатанд орлуулалт хийгдээгүй.


### Дундаж дуудлага хийх оролдлого

Бүрэн авсан ярилцлагын дуудлага хийх оролдлогын дундаж тоо, хот хөдөөгөөр



### Ярилцлагын хугацаа

Ярилцлагын голч хугацаа, хот хөдөөгөөр




Ярилцлагын үеэр тасалдсаны улмаас 1-р шатанд 191 өрхийн ярилцлага, 2-р шатанд 203 өрхийн ярилцлагын үргэлжлэх хугацаа 0-ээс бага эсвэл 60 минутаас их гарсан. Эдгээр өрхүүдийг голч хугацааг тооцоход оруулаагүй.




## Ундны усны суурь үйлчилгээний хэрэглээ

Ундны усны суурь үйлчилгээгээр хангагдсан өрхийн хүн амын хувь




Ундны усны суурь үйлчилгээгээр хангагдсан өрхийн хүн амын хувь, шинж байдлаар




Ундны усны суурь үйлчилгээгээр хангагдсан хүн ам Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлт (ТХЗ 1.4.1) бөгөөд сайжруулсан эх үүсвэртэй бөгөөд ус авахдаа 30 минутаас доош хугацаа зарцуулдаг. Сайжруулсан эх үүсвэр гэдэгт усыг аюулгүй байлгах нөхцлийг хангасан байхыг ойлгох бөгөөд үүнд: төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон, хамгаалагдсан булаг шанд, хамгаалагдсан гүний худаг, хамгаалагдсан гар худаг, хурйн ус, савласан ус, зөөврийн усны үйлчилгээ зэрэг багтана. Хязгаарлагдмал гэдэг нь сайжруулсан эх үүсвэртэй боловч 30 ба түүнээс дээш минут зарцуулдаг. Сайжруулаагүй эх үүсвэр гэдэг нь хамгаалагдаагүй гар худаг, хамгаалагдаагүй булаг, гол, нуур, усжуулалтын суваг зэрэг гадаргын ус багтана.

## Ариун цэврийн байгууламжийн хэрэглээ

Сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэж буй өрхийн хүн амын хувь



Сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэж буй өрхийн хүн амын хувь, шинж байдлаар



Сайжруулсан ариун цэврийн байгууламж нь бохирыг хүнтэй хүрэлцэхээс хамгаалсан буюу үүнд: нэгдсэн ариун цэврийн байгууламж руу урсгадаг, битүү тунгаагуур руу урсгадаг, нүхэн жорлон руу урсгадаг ус татуургын бие засах газар, агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлон, энгийн нүхэн жорлон, био жорлон зэрэг багтана. Хязгаарлагдмал гэдэгт сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэдэг боловч бусад өрх/хүнтэй хамтарч ашигладаг тохиолдол багтана. Сайжруулаагүй ариун цэврийн байгууламж нь газрын гадарга руу урсдаг ус татуургын бие засах газар, задгай нүх зэрэг багтана. Үйлчилгээ хангагдаагүй гэдэгт хээрийн нөхцөлд бие засдаг тохиолдлыг ойлгоно.


Өрхийн хүн амын 92 хувь нь ундны усны суурь үйлчилгээгээр хангагдсан байна. Гэвч өрхийн аж байдлын түвшин доогуур өрхүүдийн хувьд энэ үзүүлэлт 69 хувь байна. Утсаар мэдээлэл цуглуулж буй өрхийн судалгааны хувьд усны чанарыг хэмжих боломжгүй тул аюулгүй зохион байгуулагдсан ундны усны үйлчилгээ (Монгол Улсын хувьд ТХЗ-ын гол үзүүлэлт)-г тооцох боломжгүй. Өрхийн хүн амын 95 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг байна. Хөдөө орон нутаг, баруун бүсэд амьдарч буй хүн ам, ядуу өрхөд амьдарч буй хүмүүсийн хувьд энэ үзүүлэлтүүд аль аль нь доогуур хувьтай байна.



# ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ

## Өрхийн цэвэр түлшний суурь хэрэглээ, ТХЗ 7.1.2


Хоол хийх, халаалт, гэрэлтүүлэг зэрэгт цэвэр түлш, технологийг хэрэглэдэг өрхийн хүн амын хувь




Цэвэр түлш, технологи гэдэгт (ТХЗ 7.1.2) хоол хийхдээ ихэвчлэн цахилгаан зуух эсвэл газ, халаалтандаа төвлөрсөн халаалтын систем эсвэл сэргээгдэх эрчим хүч эсвэл цахилгаан халаагуур, гэрэлтүүлэгтээ цахлигаан, нарны зайн чийдэн, цэнэглэдэг эсвэл зай ашигладаг гар чийдэн ашигладаг бол хамаарна.

## Хоол хийх, халаалтандаа цэвэр түлш, технологи хэрэглээ: тэгш байдал

Хоол хийхдээ цэвэр түлш, технологи хэрэглэдэг өрхийн хүн амын хувь (хоол хийсэн гэж хариулсан өрхүүдээс), шинж байдлаар




Халаалтандаа цэвэр түлш, технологи хэрэглэдэг өрхийн хүн амын хувь (халаалт ашигласан гэж хариулсан өрхүүдээс), шинж байдлаар



## Хоол хийх, халаалт, гэрэлтүүлэгтээ цэвэр түлш, технологийн суурь хэрэглээ

Хоол хийх, халаалт, гэрэлтүүлэг зэрэгт цэвэр түлш, технологийг хэрэглэдэг өрхийн хүн амын хувь, хот хөдөө, бүс, өрхийн аж байдлын түвшингээр






## ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ


### Сайжруулсан түлш Улаанбаатарт

Хоол хийх болон халаалтандаа сайжруулсан түлш хэрэглэдэг Улаанбаатар хотын өрхийн хувь




### Сайжруулсан түлшний аюулгүй хэрэглээг дэмжих арга хэмжээ

2020 оны 11 сарын 1-ээс хойш сайжруулсан түлшний аюулгүй хэрэглээний талаар арга хэмжээнд хамрагдсан Улаанбаатар хотын өрхийн хувь



### Улаанбаатар хотын сайжруулсан түлшний бэлэн байдал


Сайжруулсан түлшийг хоол хийх болон халаалтандаа хэрэглэж буй Улаанбаатар хотын өрхүүдийн долоо хоногос бага давтамжтайгаар сайжруулсан түлш худалдан авдаг хувь



Долоо хоногт худалдан авсан сайжруулсан түлшний дундаж тоо /шуудай/



Сайжруулсан түлш авахад зарцуулсан дундаж хугацаа /минут/



Өнгөрсөн долоо хоногт хангалттай хэмжээнд сайжруулсан түлш авч чадаагүй гэж мэдээлсэн өрхийн хувь

Улаанбаатар хотын гурван өрх тутмын нэг нь сайжруулсан түлш хэрэглэж байна. Сайжруулсан түлш хэрэглэдэг өрхүүдийн 93 хувь нь долоо хоногос бага давтамжтайгаар сайжруулсан түлш худалдан авдаг байна. Сайжруулсан түлшийг долоо хоно бүр эсвэл түүнээс олон удаа худалдан авч байсан өрхүүдийн дунд: дунджаар долоо хоногт 7 шуудай сайжруулсан түлш худалдан авдаг; сайжруулсан түлш худалдан аваад буцаж ирэхэд дунджаар 29 минут зарцуулдаг бөгөөд 37 хувь нь сүүлийн долоо хоногт хангалттай хэмжээний түлш авч чадаагүй гэж мэдээлсэн байна.


Аюулгүй хэрэглээний арга хэмжээг ихэнх өрх хэрэгжүүлж байна. Энэ чиглэлийн Засгийн газрын дэмжлэг, үйлчилгээ сайжруулсан түлш хэрэглэдэг өрхүүдийн талаас илүү хувийг хамарч байна. Өрхүүдийн 71 хувь нь угаарын хийнээс хамгаалах талаар, 59 хувь нь зуухны ашиглалт, засвар үйлчилгээний талаар сайн дурын ажилтнууд/хорооны ажилтнуудаас зөвлөгөө авсан байна.



# COVID-19 болон ТОМУУГИЙН ЭСРЭГ ВАКЦИН


## Томуугийн эсрэг дархлаажуулалт

2019, 2020 онд томуугийн вакцин хийлгэсэн гишүүнтэй өрхийн эзлэх хувь



## 2020 онд томуугийн вакцин хийлгээгүй шалтгаан

2020 онд нэг ч гишүүн томуугийн вакцин хийлгээгүй өрхийн хувь, вакцин хийлгээгүй шалтгаанаар




2019 онд нийт өрхийн 43 хувь нь дор хаяж нэг гишүүн нь томуугийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан байна. Энэ үзүүлэлт 2020 онд 35 хувь болж буурсан байна.

2020 онд нийт өрхийн 65 хувь нь нэг ч гишүүн томуугийн вакцин хийлгээгүй бөгөөд вакцин хийлгээгүй үндсэн шалтгаан нь нийтийг хамарсан байгаагүй (17 хувь), вакцин байдаг гэж мэдээгүй (13 хувь) болон шаардлагагүй гэж үзсэн (8 хувь) байна.


## COVID-19-ийн эсрэг вакцины талаарх мэдлэг, хандага

COVID-19-ийн эсрэг вакцин боловсруулагдаж байгаа талаар сонссон эсэх болон вакцин боловсруулагдвал хийлгэх хариулагчийн хувь



## COVID-19 вакцины эргэлзээтэй байдал

COVID-ийн эсрэг вакцин хийлгэхгүй гэж хариулсан хариулагчийн хувь, шалтгаанаар



Ерөнхийдөө судалгаанд оролцогчдын 91 хувь нь COVID-19-ийн эсрэг вакцин боловсруулагдаж байгаа талаар сонссон байна. COVID-19-ийн вакцины талаар сонссон хүмүүсийн 74 хувь нь вакцин хийлгэнэ гэж мэдэгдсэн байна. Вакцин хийлгэхгүй гэж хариулсан 3 хариулагч тутмын 2 нь вакцинд итгэхгүй гэж хариулжээ.




# COVID-19: ОРЛОГОД НӨЛӨӨЛӨХ НЬ


## Өрхийн орлогын өөрчлөлт

2020 оны 2 дугаар сараас хойш сарын дундаж орлого нь буурсан өрхийн хувь

Өрхийн сарын дундаж орлого буурсан өрхийн хувь, орлого буурсан шалтгаанаар



Өрхийн сарын дундаж орлого буурсан өрхийн хувь, буурсан хувиар, хот, хөдөө, бүс, өрхийн тэргүүний хүйс, өрхийн аж байдлын түвшингээр



## Орлогын бууралтыг даван туулах арга хэмжээ

2020 оны 2 дугаар сараас хойш өрхийн сарын дундаж орлого нь буурсан өрхийн хувь, орлогын бууралтыг даван туулах арга хэмжээгээр



Хувь

Өрхүүдийн 57 хувь нь 2020 оны 2 дугаар сараас хойш сарын дундаж орлого нь буурсан гэж мэдээллэсэн. Орлого нь буурсан 3 өрх тутмын 2 нь хөл хорионоос болж өрхийн гишүүд нь ажиллах боломжгүй/ажилдаа явж чадаагүй нь орлого буурах гол шалтгаан болжээ.

Орлого буурсан нийт өрхийн 59 хувь нь сарын дундаж орлого нь 1-50 хувиар буурсан гэж хариулжээ.

Өрхүүд орлогын бууралтыг даван туулах янз бүрийн стратеги ашигласан байна: Өрхийн зардлыг бууруулах (81 хувь) арга нь хамгийн түгээмэл арга хэмжээ байв. Түүнчлэн өрхийн 62 хувь нь хоол хүнсээ багасгаж, 45 хувь нь найз нөхөд, гэр бүлээсээ мөнгө зээлсэн гэж хариулжээ.





# COVID-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ болон бусад асуудлууд

## COVID-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ

Өрхийн гишүүд нь халдвараас сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байгаа өрхийн хувь (хариулагчийн үнэлгээгээр), арга хэмжээний төрлөөр


Өрхийн гишүүд нь халдвараас сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байгаа өрхийн хувь (хариулагчийн үнэлгээгээр), арга хэмжээний төрөл болон хот хөдөөгөөр



## Хилийн чанадад гацсан гишүүнтэй өрх

2020 оны 2 дугаар сараас хойш COVID-19-оос шалтгаалан хилийн чанадад гэр бүлийн гишүүн нь гацсан өрхийн хувь

Хилийн чанадад гацсан гэр бүлийн гишүүнтэй өрхийн хувь, буцаж ирж чадахгүй байгаа шалтгаанаар



## COVID-19-той холбоотой санаа зовоож буй зүйлс

COVID-19-той холбоотой санаа зовоож буй зүйлсээрх хариулагчийн хувь



Ерөнхийдөө COVID-19 халдвараас сэргийлэх арга хэмжээнүүдийг хот суурин газруудад хөдөө орон нутгаас илүү хэрэгжүүлж байна. Судалгаанд оролцогчдын 69 хувь нь олон нийтийн газар очихоос зайлсхийсэн байна. ОУБТС+ судалгааны 2 дугаар шатны мэдээллийг хөл хорионы үеэр цуглуулсан болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Нийт өрхүүдийн 7 хувь нь гэр бүлийн хэн нэг нь 2020 оны 2 дугаар сараас хойш COVID-19-оос шалтгаалан хилийн чанадад гацсан ба тэдний 40 хувьд нь гол шалтгаан нь хил хаагдсан явдал байв.


Судалгаанд оролцогчдын COVID-19-той холбоотой хамгийн их санаа зовоож буй зүйл нь өрхийн гишүүн өвчлөх айдас байна (45 хувь). Судалгаанд оролцогчдын дөрөвний нэгээс илүү нь (27 хувь) COVID-19-той холбоотой санаа зовох зүйлгүй гэж харилжээ.



# ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ ХӨТӨЛБӨР

## Хүүхдийн мөнгөн тэтгэмж хөтөлбөр

Хүүхдийн мөнгө авдаг 18 хүртэлх насны хүүхдийн хувь



■ ХМ авдаг ■ ХМ авдаггүй

## Хүүхдийн мөнгө хадгалалт

Хүүхдийн мөнгө авдаг бөгөөд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэхээс өмнө ба дараа нь хүүхдийн мөнгөний зарим хэсгийг нь эсвэл бүгдийг нь хадгалдаг байсан 18 хүртэлх насны хүүхдийн хувь



■ Хадгалдаг ■ Хадгалдаггүй




■ Хадгалдаг ■ Хадгалдаггүй

2005 оноос хэрэгжиж эхэлсэн хүүхдийн мөнгөн тэтгэмж хөтөлбөр нь 18 хүртэлх насны бүх хүүхдэд хүртээмжтэй, бэлэн мөнгө шилжүүлэх хөтөлбөр болж хөгжсөн. 2012 оны 10 дугаар сараас хойш сар бүр олгох тэтгэмж 20000 төгрөг байсан бөгөөд 2020 оны 4 дүгээр сард Засгийн газраас Covid-19 цар тахалын нөлөөг бууруулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээний нэг болж нэмэгдсэн. Монгол Улсын Засгийн газар хүүхдийн мөнгөн тэтгэмж хөтөлбөрт үндэслэн нийгмийн хамгаалмын чиглэлээр цочролт хариу үзүүлэх томоохон амжилтанд хүрсэн.


## Хүүхдийн мөнгийг нэмэгдүүлэхээс өмнөх хадгалах хандлага (20,000₮)

Хүүхдийн мөнгө авдаг бөгөөд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэхээс өмнө хүүхдийн мөнгөний зарим хэсгийг эсвэл бүгдийг нь хадгалдаг байсан 18 хүртэлх насны хүүхдийн хувь (20,000₮)



## Хүүхдийн мөнгийг нэмэгдүүлсний даараах хадгалах хандлага (100,000₮)

Хүүхдийн мөнгө авдаг бөгөөд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлсний дараа хүүхдийн мөнгөний зарим хэсгийг эсвэл бүгдийг нь хадгалдаг байсан 18 хүртэлх насны хүүхдийн хувь (100,000₮)



Нийт 18 хүртэлх насны хүүхдүүдтэй өрхүүдийн 96 хувь нь хүүхдийн мөнгө авч байна. Хүүхдийн мөнгөний хэмжээ өөрчлөгдөхөөс өмнө болон дараа хүүхдийн мөнгөө хадгалж байгаа хэв маягт өөрчлөлт орсон эсэхийг тодруулах асуулт тавьсан. Хүүхдийн мөнгө авч буй өрхүүдийн 44 хувьд нь хүүхдийн мөнгийг нэмэгдүүлэхээс өмнө зарим хэсгийг эсвэл бүгдийг нь хадгалж байсан байна. Энэ хувь хүүхдийн мөнгийг нэмэгдүүлсний дараа 39 хувь болж буурчээ. Хөдөөгийн өрхүүдийн хувьд хүүхдийн мөнгийг хадгалж буй хувь өөрчлөгдөөгүй байна. Харин хотын өрхүүдийн хувьд 47 хувиас 40 хувь болж буурсан байна.

Өрхийн аж байдлын түвшингээр авч үзвэл доогуур аж байдалтай өрхүүдээс бусад бүх бүлэгт хүүхдийн мөнгийг хадгалах нь буурсан байна.







# ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХООЛ ТЭЖЭЭЛ

## Хүнсний аюулгүй байдал

Хүнсний аюулгүй байдлын түвшин (Food Insecurity Experience Scale)-ний дагуу хүнсний аюулгүй байдал нь дунд болон хүнд байгаа өрхийн хүн амын хувь (ТХЗ-ын үзүүлэлт 2.1.2), хот хөдөө, бүс, өрхийн аж байдлын түвшингээр



## Нялхас болон бага насны хүүхдийн хооллолт



**Эхийн сүүгээр дагнан хоолож байгаа:** Зөвхөн эхийн сүүгээр хоолож байгаа 0-5 сартай хүүхдийн хувь; **Зохих нэр төрлийн хүнс хэрэглэж байгаа:** Зөвлөсөн 8 төрлийн хүнсний бүлгээс наад зах нь 5 төрлийн орцоор хоолосон 6-23 сартай хүүхдийн хувь; **Зохих давтамжаар хоолож байгаа:** Зөвлөмжийн дагуу хүүхдийн насанд тохирсон давтамжтайгаар өтгөн, шингэн хоолоор хоолож байгаа 6-23 сартай хүүхдийн хувь; **Зохистой байдлаар хоолож байгаа:** Зохистой давтамжаар хоолож байгаа бөгөөд зохис нэр төрлийн хүнс хэрэглэж байгаа 6-23 сартай хүүхдийн хувь; **1 нас хүртэл эхийн сүүгээр хоолож байгаа:** Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хоолож байгаа 12-15 сартай хүүхдийн хувь; **2 нас хүртэл эхийн сүүгээр хоолож байгаа:** Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хоолож байгаа 20-23 сартай хүүхдийн хувь. Бүх үзүүлэлтийг судалж буй хүн амын янз бүрийн бүлгийн хувьд энэ зарчмыг (өөрөөр хэлбэл тодорхой насны бүлгийн хүүхдүүд) хэрэвхүү хэрэгжүүлж байгааг сүүлийн 24 цагийн хугацаанд тодорхойлж буй хэрэг юм.

Монгол Улсын хувьд хүнсний аюулгүй байдлын дунд болон хүнд зэргийн хэмжээ 23 хувь байгаа бөгөөд хот суурин газар, өрхийн аж байдлын түвшин дунджаас доогуур өрхүүдийн хувьд тархалт харьцангуй өндөр байна. Хүнсний аюулгүй байдлын хүнд хэлбэр нь хүн амын 1 хүрэхгүй хувьд илэрч байна.

6-23 сартай хүүхдүүдийн 36 хувь нь зохих байдлаар хоолож байна (зохих нэр төрлийн хүнсийг зохих давтамжтайгаар), энэ нь зохих нэр төрлийн хүнс хэрэглэж байгаа (8 төрлийн хүнсний бүлгээс наад зах нь 5 төрлийн орцоор хоолосон) хүүхдийн хувь бага байгаагаар холбоотой.

ОУБТС+ судалгааны үр дүнгийн дашбоард болон илүү их мэдээллийг дараах хаягаар үзэх боломжтой:

НҮБ-ын Хүүхдийн Сангийн MICS Plus олон улсын цахим хуудас <https://mics.unicef.org/mics-plus/mics-plus-results#mongolia>

Монгол Улсын ҮСХ-ны мэдээллийн цахим хуудас <https://www.1212.mn/survey.mn.aspx>

### Үндэсний Статистикийн Хороо



**Хаяг:** Засгийн газрын III байр, Бага тойруу – 44 Улаанбаатар – 11, Монгол Улс



**Утас:** (+976) 11-326414



**Лавлах утас:** 1900-1212



**Факс:** (+976) 11-324518



**Цахим хуудас:** [www.nso.mn](http://www.nso.mn)

**Цахим шуудан:** [information@nso.mn](mailto:information@nso.mn)



**Биднийг дагаарай**

Facebook | @StatisticMongolia



Twitter | @Statistic\_nso

### НҮБ-ын Хүүхдийн Сан Монгол дахь оффис



**Хаяг:** НҮБ-ын Нэгдсэн байр. Нэгдсэн Үндэстний гудамж-14, Улаанбаатар 14201, Монгол Улс



**Утас:** (+976) 11-312217



(+976) 11-312185



**Цахим хуудас:** [www.unicef.org/mongolia](http://www.unicef.org/mongolia)



**Цахим шуудан:** [ulaanbaatar@unicef.org](mailto:ulaanbaatar@unicef.org)



**Биднийг дагаарай**

Facebook | @unicefmongolia



Twitter | @UNICEF\_Mongolia